



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 1.4 дэх хэсэг, “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулахыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА



Т.АУБАКИР

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2026 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хавсралт



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС
САНХҮҮЖҮҮЛЭХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэг- жүүлэх хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6
1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгаа;					
1.1	Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн ажил олгогчдын удирдах ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах;	Сургалтад хамрагдах удирдах ажилтнуудын тоо	Удирдах ажилтан-6,000	II-IV улирал	ХАБЭМТ
1.2	Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, ХАБЭМ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах; (Улаанбаатар хотод)	Сургалт хэлэлцүүлгийн тоо Мэргэжилтнүүдийн хамрагдалтын хувь	Сургалт хэлэлцүүлэг-1 Мэргэжилтнүүдийн 90 хувь	II-IV улирал	ГБХНХЯ
1.3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинээр батлагдсан хууль тогтоомж, журам, техникийн зохицуулалтыг олон	Сургалт, зөвлөгөөний тоо Сургалтад хамрагдах албан тушаалтны тоо	Сургалт зөвлөгөөн-7 Сургалтад хамрагдах албан тушаалтан-500	II-IV улирал	ХАБЭМТ

	нийтэд сурталчлах, хэрэгжилтийг дэмжих сургалт, зөвлөгөөн зохион байгуулах;	Сурталчилгааны богино хэмжээний видео, зурагт хуудасны тоо Сурталчилгааны хандалтын тоо	Богино хэмжээний видео, зурагт хуудас-7 Сурталчилгаа хүргэх хүний тоо-20,000		
1.4	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сарын аян-2026” арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;	Зохион байгуулах арга хэмжээний тоо Сурталчилгааны контентын тоо	Салбарын онцлогт тохирсон арга хэмжээ-5 Сурталчилгааны контент-2	II улирал	ХАБЭМТ
1.5	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх;	Мэдээллийн хэрэгслээр түгээх контентын тоо Мэдээлэл хүргэсэн хүний тоо	Контентын тоо-3 Мэдээлэл хүргэсэн хүний тоо-100,000	II-IV улирал	НДЕГ
1.6	Бизнес эрхлэгч байгууллагуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой сурталчилгааны ажлыг зохион байгуулах;	Сурталчилгааны ажлын тоо	Сурталчилгааны контент-1	II-III улирал	НДЕГ
1.7	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах;	Сургалтад хамрагдах байцаагч, ажилтнуудын тоо;	Сургалтад хамрагдах байцаагч, ажилтнууд-500	II-IV улирал	ГБХНХЯ
1.8	Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх;	Бэлтгэж, түгээх хууль тогтоомжийн эмхэтгэлийн тоо	Хууль тогтоомжийн эмхэтгэл -3,500	III-IV улирал	НДЕГ



1.9	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомж түүний ач холбогдлыг сурталчилсан маркетингийн бүтээгдэхүүн бэлтгэх, олон нийтэд түгээх;	Маркетингийн бүтээгдэхүүн түгээх ажил олгогчдын тоо	Ажил олгогч-200		
1.10	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах;	Зохион байгуулах сургалтын тоо Хамрагдах ажил олгогчийн тоо	4 удаагийн сургалт 150 ажил олгогч	II-IV улирал	НДЕГ
1.11	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтын сурах бичгийг боловсруулах, хэвлүүлэх, ажил олгогч, даатгуулагчдад түгээх;	Боловсруулах, түгээх сурах бичгийн тоо	Сурах бичиг боловсруулах-1 Түгээж, хэвлүүлэх тоо-500	II-IV улирал	ХАБЭМТ
2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт;					
2.12	Ажил олгогч, даатгуулагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг үндэсний түвшинд (21 аймаг, 9 дүүрэг, 42 суманд) зохион байгуулах;	Сургалтын тоо Сургалтад хамрагдах хүний тоо	Сургалтын тоо-90 Сургалтад хамрагдах хүний тоо- 2000	II-IV улирал	ХАБЭМТ
2.13	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн (https://inspection.hudulmur-halamj.gov.mn/) системийн шинэчилсэн хувилбарыг танилцуулах сургалтыг ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагуудад зохион байгуулах (МАОЭНХ, МҮХАҮТ, МҮЭХ)	Зохион байгуулах сургалтын тоо Сургалтад хамрагдах албан тушаалтнуудын тоо	Сургалтын тоо-1 Сургалтад хамрагдах албан тушаалтан-100	II улирал	ГБХНХЯ
2.14	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэл бүхий салбарт үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг олон улсын зөвлөх, профессоруудтай хамтран зохион байгуулах;	Зохион байгуулах сургалтын тоо Сургалтад хамрагдсан сургагч багш нарын тоо	Сургалтын тоо-2 Сургалтад хамрагдах сургагч багш нарын тоо-50	II-IV улирал	ХАБЭМТ

2.15	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг ажил олгогч, даатгуулагчдад зохион байгуулах сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах; (21 аймгийн хэмжээнд сургагч багш бэлтгэх)	Сургагч багшийн сургалтад хамрагдсан хүний тоо	Сургагч багш-100		
2.16	Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг (тоосны шалтгаант) эрт оношлох, мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах;	Зохион байгуулах сургалтын тоо Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтнуудын тоо	Сургалтын тоо-1 Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтнуудын тоо-50	II-III улирал	ХАБЭМТ
2.17	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн "Аюулгүй ажлын байр" сэдэвт сургалт, зөвлөгөөнийг ажил олгогчдод зохион байгуулах;	Хамрагдах ажил олгогчийн тоо	Хамрагдах ажил олгогчийн тоо-200	II улирал	ХАБЭМТ
2.18	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "SOLVE" хөтөлбөрийн хүрээнд ажлын байрны эрүүл мэндийг дэмжих сургалтыг зохион байгуулах;	Зохион байгуулах сургалтын тоо Хамрагдах ажил олгогчийн тоо	Сургалтын тоо-1 Сургалтад хамрагдах ажил олгогчийн тоо-10	II-III улирал	ХАБЭМТ
2.19	Барилгын салбарын ажил олгогчдод Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын аян зохион байгуулах;	Сургалтын тоо Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	Аяны хүрээнд зохион байгуулах сургалт-4 Сургалтад хамрагдсан ажилтан-150	II-III улирал	ХАБЭМТ
2.20	Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнууд болон үйлдвэрчний эвлэлийн хороодын дарга нарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулж, гарын авлагаар хангах;	Сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтнуудын тоо	Сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилчдын тоо-200	II улирал	ХАБЭМТ
2.21	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуун сухайтын боомтоор нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг тээвэрчдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс	Сургалт, өдөрлөгийн тоо Сургалтад хамрагдах даатгуулагчдын тоо	Сургалт, өдөрлөг-4 удаа Сургалтад	II-IV улирал	НДЕГ

	шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, өдөрлөг зохион байгуулах;		хамрагдах даатгуулагч-8,000		
2.22	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Эрүүл чанартай амьдралын төлөө” сэдэвт салбар хоорондын хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулах;	Сургалт, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо	Сургалт, хэлэлцүүлэг-1, Оролцогч байгууллага-5 Оролцогчдын тоо-60	IV улирал	НДЕГ
2.23	Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин хөдөлмөрийн чадвар алдалтад нөлөөлж буй шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зүйн сургалтыг зохион байгуулах; (баруун, зүүн)	Зохион байгуулах сургалтын тоо Сургалтад хамрагдах эмч, мэргэжилтнүүдийн тоо	2 удаагийн сургалт Сургалтад хамрагдах эмч, мэргэжилтнүүд-123	III улирал	НДЕГ
3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт амжилтыг олон нийтэд сурталчлах;					
3.24	Олон улсын түвшинд мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй шинэ техник, технологи, инновацыг Монгол улсад нэвтрүүлэх, олон нийтэд сурталчлах “Хөдөлмөрийн эрүүл ахуйн олон улсын чуулган” зохион байгуулах;	Олон улсын чуулганы тоо Чуулганд хамрагдах улс, байгууллага, оролцогчийн тоо	Олон улсын чуулган-1 Азийн 6 улс, 50 байгууллагын 300 оролцогч	III улирал	ГБХНХЯ
3.25	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрдэм шинжилгээний чуулган” зохион байгуулах;	Эрдэм шинжилгээний чуулганы тоо Оролцогчдын тоо	Эрдэм шинжилгээний чуулган-1 4-6 салбарын 100 оролцогч	II улирал	ХАБЭМТ
3.26	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн энтерпренер-2026” тодруулж, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах;	Шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээний тоо Шалгарсан байгууллагын тоо	Шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ-1 Шалгаруулах байгууллага-3	II-IV улирал	ХАБЭМТ





3.27	Мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Англи, Австрали улсад хэрэгжүүлсэн “Чөлөөтэй амьсгалъя” санаачилгыг Монгол Улсад нэвтрүүлэх;	Цахим мэдээллийн сангийн тоо Санаачилгыг нэвтрүүлсэн өндөр эрсдэлтэй ажил олгогчийн тоо	“Чөлөөтэй амьсгалъя” (Breathe Freely) цахим мэдээллийн сан-1 “Чөлөөтэй амьсгалъя” (Breathe Freely) санаачилгыг нэвтрүүлсэн ажил олгогч-5	II-IV улирал	ХАБЭМТ
3.28	ҮОМШӨ-ний 2024-2025 оны статистик мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн сайн туршлагыг цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах;	Сургалт, сурталчилгааны тоо Түгээлтийн тоо	Сайн туршлагыг дэлгэрүүлэх контент-25 Контентын хандалт-20,000	II-IV улирал	ХАБЭМТ
3.29	Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн шилдэг туршлагыг олон нийтэд сурталчлах;	Сурталчилгааг хүргэх ажил олгогчийн тоо	4-6 салбарын 100 ажил олгогч	II-IV улирал	ХАБЭМТ
3.30	Хувийн хэвшлийн бичил, жижиг ажил олгогчдоос “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн манлайлагч байгууллага” (OSH Excellence awards) арга хэмжээг зохион байгуулж, тэдний сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;	Зохион байгуулах арга хэмжээний тоо Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажил олгогчийн тоо	Зохион байгуулах арга хэмжээ-1 Ажил олгогч-15	II-IV улирал	ХАБЭМТ
3.31	“Осолгүй ажлын соёл” ХАБЭА-н шилдэг туршлагыг түгээсэн гарын авлага боловсруулан түгээх;	Гарын авлагын тоо	Гарын авлага-1000	II-III улирал	ХАБЭМТ
3.32	Улс орнуудын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо, шилдэг туршлагыг судлах, судалгаа хийх;	Туршлага судлах улс орны тоо	Танилцах, туршлага судлах улс-2	II-IV улирал	НДЕГ

4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт, шинжилгээ, үнэлгээ					
4.33	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэл бүхий ажил олгогчдод үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр эрсдэлийн үнэлгээг (үндэсний хэмжээнд) зохион байгуулж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах талаар зөвлөмж өгөх;	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдах ажил олгогчийн тоо Зөвлөмж хүргүүлсэн ажилт олгогчийн тоо	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдах ажил олгогч-144 (Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг, 42 сумын)	улирал	ХАБЭМТ
4.34	Уул уурхай, үйлдвэрийн төвлөрөл бүхий 10 аймгийн ажил олгогчдод мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр тандан судалгаа хийх;	Мэргэжлээс шалтгаалсан өвчний тандан судалгаанд хамрагдсан ажилтны тоо	Тандан судалгаанд хамрагдах ажилтан-1800	II-IV улирал	ХАБЭМТ
4.35	Тоосжилтын улмаас үүсэж буй мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар тандан судалгааг хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;	Тандан судалгаанд хамрагдах ажилтны тоо	Таван толгойн нүүрсний бүлэг ордуудад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн 1000 ажилтан	II-III улирал	ХАБЭМТ
4.36	Уул уурхайн салбарын өндөрт ажиллах үед мөрдөх стандарт, техникийн зохицуулалт, ил уурхайн ажил гүйцэтгэхэд мөрдөх аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтуудын төслийг шинэчлэн боловсруулах; (салбарын үйлдвэрлэлийн ослын 2023-2025 оны статистик мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээг үндэслэх)	Хяналт шинжилгээ, үнэлгээний тоо Зохион байгуулах хэлэлцүүлгийн тоо Техникийн зохицуулалтын төслийн тоо Стандартын төслийн тоо	Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан -17 Хэлэлцүүлэг-6 Техникийн зохицуулалтын төсөл-2 Стандартын төсөл-15	II-IV улирал	ХАБЭМТ
4.37	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх стратегийг тодорхойлох тандан судалгаа хийх;	ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх стратегийн бодлого	ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх стратегийн бодлого-1	II-III улирал	ХАБЭМТ



4.38	Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудад мэргэжлээс шалтгаалсан өвчний "Үзлэгт суурилсан судалгаа"-г хийж, урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх;	Судалгаанд хамрагдах эмч ажилтнуудын тоо	Судалгаанд хамрагдах эмч, мэргэжилтнүүд-250		
4.39	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон тэтгэврийн даатгалын сангийн өнөөгийн нөхцөлд иж бүрэн үнэлгээг хийлгэх;	Иж бүрэн үнэлгээний тайлан Тайлан хүргүүлсэн байгууллагын тоо	Иж бүрэн үнэлгээний тайлан-1 Тайлан хүргүүлсэн байгууллагын тоо-2	II-IV улирал	НДЕГ
4.40	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын тоо өндөр аймгуудад эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аймгуудын тоо Хяналт шалгалтад хамрагдах ХЧА-сан иргэдийн тоо	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аймаг-2 (Хэнтий, Дорноговь) Хяналт шалгалтад хамрагдах ХЧА иргэд-1,200	II-III улирал	НДЕГ
4.41	Нийгмийн даатгалын ерөнхий газартай "Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан сэргээн засах болон сувиллын байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ хийх, зөвлөмж өгөх;	Үнэлгээ хийх сувиллын байгууллагуудын тоо	Сувиллын байгууллага-4	III-IV улирал	НДЕГ

---o0o---